"АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ" ХХК-ийн
Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан
2020 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**454,146,232.82**	**734,453,962.99**
Зээлийн эргэн төлөлтийн орлого	117,245,288.02	130,218,542.99
Зээлийн хүүгийн орлого	18,753,193.93	1,878,103.40
Харилцах дансны хүүгийн орлого	1,360,072.87	111,216.60
Гадаад валютын арилжааны орлого	3,080,000.00	872,000.00
Гадаад валютын ханшийн зөрүү	313,707,678.00	601,374,100.00
Буцаан авсан албан татварын мөнгөн орлого	**769,751,941.18**	**723,643,223.92**
Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого	659,221,219.27	14,401,838.32
Бусад үйлчилгээний орлого	10,501,004.00	7,132,311.59
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	78,574,669.00	75,286,925.00
Зээлд гарсан мөнгөн зарлага	10,141,833.00	9,315,168.00
Буцаан олгосон хадгаламж	245,530.00	387,110.00
Хүүгийн төлбөр	327,211.00	138,247.01
Ажиллагсдад олгосон мөнгө	164,150.00	126,000.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	6,151,324.91	4,795,624.00
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	125,000.00	260,000.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1,000,000.00	1,000,000.00
Шатахуун, холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	3,300,000.00	3,300,000.00
Татвар, даатгалд төлсөн мөнгө		607,500,000.00
Албан томилолт, сургалтын зардал, аудит	**(315,605,708.36)**	**10,810,739.07**
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө		
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө		
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө		
Бусад		
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**200,000,000.00**	**-**
Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого		
Ноогдол ашгийн орлого		
Бусад	200,000,000.00	
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**-**	**500,000.00**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Торгуулийн зардал		500,000.00
Бусад		
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**200,000,000.00**	**(500,000.00)**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(115,605,708.36)**	**10,310,739.07**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**2,550,302,327.94**	**2,434,696,729.06**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**2,434,696,729.06**	**2,445,007,468.13**

"АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ" ХХК-ийн
Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан
2020 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

	Хувьцаат капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12 сарын 31-ний өдөр	**2,200,000,000.00**		**513,421,735.23**	**2,713,421,735.23**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	**2,200,000,000.00**	**-**	**513,421,735.23**	**2,713,421,735.23**
Тайлант үеийн цэвэр ашиг			23,500,544.83	**23,500,544.83**
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчийн гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
Хувьцаат капиталын өсөлт				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,200,000,000.00**	**-**	**536,922,280.06**	**2,736,922,280.06**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(257,220.62)	**(257,220.62)**
Залруулсан үлдэгдэл	**2,200,000,000.00**	**-**	**536,665,059.44**	**2,736,665,059.44**
Тайлант үеийн цэвэр ашиг			(8,649,650.59)	**(8,649,650.59)**
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчийн гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
Хувьцаат капиталын өсөлт				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,200,000,000.00**	**-**	**528,015,408.85**	**2,728,015,408.85**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ" ХХК-ийн
Аудитлагдсан орлого, үр дүнгийн тайлан
2020 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

	Тодот гол	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
ХҮҮГИЙН ОРЛОГО		**117,245,288.02**	**130,218,542.99**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	10	112,246,156.87	127,685,753.57
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	10	4,999,131.15	2,532,789.42
Харилцах дансны хүүгийн орлого			
Бусад орлого			
Хүүгийн орлогын бууцаалт			
ХҮҮГИЙН ЗАРДАЛ		**10,501,004.00**	**7,132,311.59**
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал		10,501,004.00	7,132,311.59
Хүүгийн зардлын буцаалт			
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО		**106,744,284.02**	**123,086,231.40**
ХҮҮГИЙН БУС ОРЛОГО		**25,645,524.57**	**3,057,336.00**
Арилжааны цэвэр орлого	10	20,827,540.00	2,043,549.40
Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого	10	3,080,000.00	872,000.00
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	10	1,737,984.57	141,786.60
Бусад орлого			
ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ		**106,278,092.11**	**105,201,782.99**
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	11	2,452,257.77	196,016.00
Боловсон хүчний холбогдолтой зардал	12	89,463,502.00	84,995,922.00
Бусад зардал	13	14,362,332.34	20,009,844.99
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ ЗАРДАЛ		**(80,632,567.54)**	**(102,144,446.99)**
Болзошгүй эрсдлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг алдагдал		**26,111,716.48**	**20,941,784.41**
БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН ЗАРДАЛ		**-**	**34,000,000.00**
Зээлийн эрсдлийн зардал			34,000,000.00
Найдваргүй авлагын нөөцийн зардал			
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/		**26,111,716.48**	**(13,058,215.59)**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого			4,908,565.00
Үндсэн бус үйл ажиллагааны зардал			500,000.00
ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/		**26,111,716.48**	**(8,649,650.59)**
Ердийн бус орлого			
Ердийн бус зардал			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		**26,111,716.48**	**(8,649,650.59)**
Орлогын албан татвар	14	2,611,171.65	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		**23,500,544.83**	**(8,649,650.59)**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ" ХХК-ийн
Аудитлагдсан баланс
2020 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

	Тодот гол	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
ХӨРӨНГӨ			
Мөнгөн хөрөнгө		**2,434,696,729.06**	**2,445,007,468.13**
Бэлэн мөнгө	3	2,434,583,928.68	2,443,529,022.66
Банк санхүүгийн байгууллага дахь хадгаламж			
Банк санхүүгийн байгууллага дахь харилцах	3	112,800.38	1,478,445.47
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)			
Зээл (цэврээр)		**457,510,271.60**	**298,600,000.12**
Хэвийн зээл	4	457,510,271.60	298,600,000.12
Хугацаа хэтэрсэн зээл			
Чанаргүй зээл			34,000,000.00
Зээлийн эрсдэлийн сан			(34,000,000.00)
Санхүүгийн түрээсийн тооцооны авлага			
Факторингийн тооцооны авлага			
Санхүүгийн деривативын авлага			
Бусад авлага		**9,747,992.42**	**16,667,796.91**
Бусад авлага			
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	5	9,747,992.42	16,667,796.91
Бусад хөрөнгө		-	-
Урьдчилж төлсөн тооцоо	6		
Материал үнэ бүхий зүйл			
Нийт эргэлтийн хөрөнгө		**2,901,954,993.08**	**2,760,275,265.16**
Эргэлтийн бус хөрөнгө (цэврээр)			
Үндсэн хөрөнгө	7	1,925,334.46	1,135,004.79
Биет бус хөрөнгө	7	2,550,144.30	4,046,144.30
Нийт эргэлтийн бус хөрөнгө		**4,475,478.76**	**5,181,149.09**
НИЙТ ХӨРӨНГӨ		**2,906,430,471.84**	**2,765,456,414.25**
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр (цэврээр)			
Бусад өр төлбөр			
Цалингийн өглөг			
НДШ, ЭМДШ-н өглөг			
ХХОАТ-ын өглөг	8	594,279.51	1,129,542.13
Орлогын албан татварын өглөг	8	2,247,245.27	2,504,545.27
Бусад пассив			1,140,250.00
Салбар хоорондын тооцооны өглөг			
Урт хугацаат өр төлбөр	9	166,666,667.00	32,666,668.00
НИЙТ ӨР ТӨЛБӨР		**169,508,191.78**	**37,441,005.40**
Эзэмшигчдийн өмч			
Энгийн хувьцаа	10	2,200,000,000.00	2,200,000,000.00
Хуримтлагдсан ашиг алдагдал	10	536,922,280.06	528,015,408.85
ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН		**2,736,922,280.06**	**2,728,015,408.85**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН		**2,906,430,471.84**	**2,765,456,414.25**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Accurate Audit
АККУРЭЙТ-АУДИТ ХХК
210136, Улаанбаатар хот, УБД 9018001030
Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо,
Эрхүүгийн гудамж 7/1 байр 301 тоот
Утас:(976) 7000 3743, 99094783, 99101755
Факс:(976)-11-323743, 7000-3743, 7732-3743
audit@accurate.mn, http://www.accurate.mn

2021.03.30 № А075/21(1)

танай _____-ны № _____-т

"АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ" ХХК -ИЙН
ЗАХИРАЛ Б. БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Дүгнэлт

Бид "АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ" ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар "АРВИЖИХ КАПИТАЛ ББСБ" ХХК -ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Энэхүү аудитын ажлыг бид Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Мөн бид санхүүгийн тайлангийн аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуух үүрэг хариуцлагаа компаниас хараат бусаар бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь энэхүү дүгнэлтийг гаргах хангалттай тохиромжтой үндэслэл болсон гэдэгт итгэж байна.

Удирдлагын үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.